

## САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНААС:

### СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ДҮНГИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Монгол Улсын Сангийн Сайдын баталсан нэгдсэн удирдамжаар Сэлэнгэ аймгийн Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтэст 2017 оны 1-р улиралд санхүүгийн хяналт шалгалт хийлээ.

Өмнөх хяналт шалгалтуудын түүхийг судлахад Сэлэнгэ аймгийн Аудитын газраас 2015 он, 2016 оны санхүүгийн үйл ажиллагааг шалгаж, санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн хяналт шалгалтаар дараах зөрчил дутагдал:

-Сэлэнгэ аймгийн ЭМНД хэлтэс нь 2016 онд **43528,1** мянган төгрөгийн төсөв хэтрүүлэн зарцуулж өр төлбөр үүсгэсэн,

- Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дугаар тогтоолоор “шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-г баталсаны дагуу 2016 оны мэдээлэл байршуулалтыг шалгахад Нийгмийн даатгалын сангийн байршуулбал зохих мэдээллүүдийг байршуулсан, харин байгууллагын мэдээлэл байршуулалт **35,6%**-тай,

-Жилд батлагдсан төсөвт шатахууны 80 гаруй хувийг хэлтсийн үйл ажиллагаа, дотоод ажилд зарцуулсан, хяналт шалгалтын ажилд **20** хүрэхгүй хувийг зарцуулсан нь хэлтсээс дотоод хяналтын ажил үндсэндээ явагдаагүй байгааг илтгэж байгаа,

-Хөтөлийн ЦШХК-ны нийгмийн даатгалын шимтгэлийн төлөх өрийг барагдуулах нэрээр хувийн аж ахуйн нэгж байгууллагуудад зээлээр цемент ачуулаад төлүүлээгүй зэрэг зөрчил дутагдлыг улсын ахлах байцаагчийн эрх үүргийн хүрээнд шийдвэрлэн төлбөрийн акт тогтоосон.

Үүнд:

1. Цагааннуур сумын нийгмийн даатгалын байцаагч Ч.Болортуяад цалингийн зөрүү 501664 төгрөгийг нөхөн олгох акт, Хавсран ажиллуулсан албан тушаалын цалингийн зөрүү 103017 төгрөг, ээлжийн амралтын зөрүү 549641 төгрөг, хэлтсийн ажилтнуудын ээлжийн амралт бодохдоо унаа хоолны хөнгөлөлтийг нэмж бодсоны зөрүү 1536616 төгрөг, давхардуулан илүү олгосон 775260 төгрөг, төрийн нууцын зэрэглэл тогтоогоогүй, тагнуулын байгууллагаас хамрагдах эсэх талаар зөвшөөрөл аваагүйгээр архив, бичиг хэргийн ажилтануудад нууцын 40%-ийн нэмэгдэл олгосоны 1732626 төгрөг нийт **5199094** төгрөгийн төлбөрийн акт, ажилтнуудын ажилласан жил, дадлага туршлага, ажлын үр дүнг харгалзахгүйгээр цалингийн шатлалын эцсийн шатлал 5-р шатлалаар үндсэн цалинг

тогтоон хавтгайруулан олгосон, төрийн үйлчилгээний ажилтнуудын цалинг төрийн захиргааны ангилалд оруулан цалинжуулсан зэрэг цалин хөлстэй холбоотой илэрсэн 31722390 төгрөгийн зөрчлийг засч залруулах хугацаатай албан шаардлага хүргүүлэн шийдвэрлэв.

2. 2016 оны 1-3 сард 230,0 мянган төгрөгийн шатахууныг байгууллагын ажлаас гадуур авсаныг Ч.Байгалмаагаар, 2016 оны 3-9 сард Дархан уул аймгаас ажилдаа ирж очдог унааны зардалд 320,0 мянган төгрөгийн шатахуун авч зарцуулсаныг Д.Уртсайханаар тус тус төлүүлэхээр акт тогтоолоо.

3. Дарга Ч.Байгалмаа нь Алтанбулаг сумын төвд барих нийгмийн даатгалын тасгийн конторын барилгын зураг төсвийг Очиртааб ХХК-аар хийлгэх гэрээг 2014 оны 06 сарын 24-ны өдөр ОСН-08/14 дугаартайгаар байгуулахдаа 13691430 төгрөгөөр гүйцэтгүүлэхээр байгуулан гэрээнд Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Ч.Байгалмаа, Барилгын зураг төслийн “Очиртааб” ХХК-ны захирал Б.Чанцалмаа нар гарын үсэг зурж байгууллагын тамга дарж баталгаажуулсан байна.

Хэдэн оны хэдэн сард хийсэн нь тодорхойгүй гэрээ байгуулсан огноогүй гэрээг шинээр хийж зураг төсвийн үнийг 23900000 төгрөг болгон нийгмийн даатгалын хэлтсийн 130090301 тоот данснаас Очиртааб ХХК-ны 409012059 дансанд Алтанбулаг сумын НДТасгийн барилгын зураг төсвийн үнэ гэж шилжүүлсэн байна. 2 дахь буюу 23900000 төгрөгийн гэрээнд Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Ч.Байгалмаа гарын үсэг зурж байгууллагын тамга дарсан, Барилгын зураг төслийн “Очиртааб” ХХК-ны захирал Б.Чанцалмаагийн нэр байгаа боловч гарын үсэг зураагүй, зөвхөн байгууллагын тамга дарсан, гэрээний үнийн дүн гүйцэтгэх, хүлээлгэн өгөх хугацааг гараар бөглөсөн, байгуулсан огноогүй байгаа тул анхны гэрээ, төсөвт суугдан шилжүүлсэн үнийн зөрүү **10208570** төгрөгийг тухайн үед даргаар ажиллаж байсан Ч.Байгалмаагаар хариуцуулан төлүүлэхээр акт тогтоов.

4.Нийгмийн даатгалын шимтгэлийн өрөнд тооцон 2014 онд олгуулсан цементний **139825,0** мянган төгрөгийг Улаанбаатар хотын Каяак конкрет ХХК-р төлүүлж сангийн орлогод төвлөрүүлэх, уг компаний эзэд олдохгүй байдал илэрч байгаа тул нь албан тушаалаа хэтрүүлэн шийдвэр гаргаж шимтгэлийн хөрөнгийг бусдад ашиглах боломж олгосон Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргаар ажиллаж байсан Ч.Байгалмааг хуулийн байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх акт тогтоов.

5. Нийгмийн даатгалын шимтгэлийн өрөнд 2014 онд гэрээгээр олгуулсан цементний **117644,5** төгрөгийг Сэлэнгэ аймгийн Таван хан ХХК-аар төлүүлэх, тогтоосон хугацаанд төлөхгүй бол албан тушаалаа хэтрүүлэн шимтгэлийн өрөнд бараа материал олгуулах шийдвэр гаргасан Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргаар ажиллаж байсан Ч.Байгалмааг хуулийн байгууллагад шилжүүлэн төлбөрийг барагдуулах заалттай акт тогтоов.

6. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр тасгийн хэмжээнд ажиллахад даатгуулагчийн тоо хүрэхгүй байхад Алтанбулаг суманд нийгмийн даатгалын тасгийн барилгыг 794400.0 мянган төгрөгөөр барьж ашиглалтад оруулсан, уг 2 давхар барилгад нийгмийн даатгалын байцаагч 1 хүн ажилладаг, газар дээр нь очиж үзэхэд 2 хана гадна дотор талдаа цууралттай, будаг, шавар ховхорсон ашиглаагүй байхад дахин засварлах

шаардлага гарч болзошгүй байдалтай, 8 сарын хугацаанд 3077,0 мянган төгрөгийн ашиглалтын зардал гарсан, цаашид хэдийн хэмжээний зардал гарч ирэхийг үгүйсгэх аргагүй чанар муутай хөрөнгө оруулалт хийгдсэн байгаа тул ашиглаагүй ашиглалтын зардал нэмж гаргахгүй талаас нь анхаарч орон нутгийн захиргаанд нь шилжүүлэн төрийн өмчийг эзэнгүйдүүлэхгүй байхаар шийдвэрлүүлэхээр улсын байцаагчийн албан шаардлага бичиж, ЭМНДЕГазарт хүргүүлээ.

7. Нийгмийн даатгалын сангийн зарцуулалттай холбоотой зөрчил- 2016 оны жилийн эцэст 1218 тоот авлагын дансанд Хөтөлийн ЦШХК-иас 2012 оноос өмнөх жилүүдэд шимтгэлийн тооцоонд цемент авч аж ахуйн нэгжид гэрээгээр олгосны 322323,1 мянган төгрөг/хавсралт 2 хуудас/-ийн эзэн холбогдогч нь тодорхойгүй, нас барсан зэрэг шалтгаантай байгаа тул холбогдох баримтыг бүрдүүлэн ЭМНДЕГазрын үндэсний зөвлөлд хандан шийдвэрлүүлэх, тэтгэвэр, тэтгэмж илүү олгосны 102137,9 мянган төгрөгийг орлого шимтгэл, хяналт шалгалтын байцаагч нарт хуваарилан барагдуулах, барагдуулсан ажилтнуудад урамшуулал олгох журмыг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын байгууллага хоорондын тооцооны 19338,5 мянган төгрөгийг тооцоо нийлж дуусгах, **443799,5** мянган төгрөгийн авлагыг барагдуулж дуусгах хугацаатай албан шаардлага хүргүүлээд байна.

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтэс нь шалгалтад хамрагдсан 2015, 2016 оны үндсэн үйл ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлэн төрийн үйлчилгээг чанартай хүргэн ажилласан, үүнээс 2016 онд сангийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн ажлын ахицтай үзүүлэлтэд хүрсэн боловч байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУСтандарт түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу хөтлөн тайлагнаагүй, төсвийн тухай хууль тогтоомжийн дагуу зохистой удирдлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн сахилга бат зөрчигдсэн, төсвийн ил тод байдал алдагдсан, 2015 онд, 2016 оны эхний улирлын хугацаанд ЭМНД-ын хэлтсийн даргаар ажилласан Ч.Байгалмаагийн шийдвэрээс болж төлбөр зөрчил гарах, төсвийн болон сангийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах байдал үүсч нийт 1543337.6 мянган төгрөгийн төлбөр зөрчил илэрсэн зэргээс **их эрсдэлтэй** байгууллага гэж дүгнэлээ.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА